



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН НОМЫН САН

МУИС-ИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН
ХӨТӨЛБӨР
2019-2024



МУИС-ИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН
ХӨТӨЛБӨР

Бодлогын баримт бичиг

УЛААНБААТАР
2019 ОН

МУИС-ИЙН ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛИЙН
2019 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 29 НИЙ
ӨДРИЙН ХУРАЛДААНААР САЙШААЖ,
МУИС-ИЙН ЗАХИРЫН 2019 ОНЫ 02
ДУГААР САРЫН 04 НИЙ ӨДРИЙН А/52
ТООТ ТУШААЛААР БАТЛАГДАВ.



АГУУЛГА

НЭГ. ҮДИРТГАЛ	
1.1 МУИС-ИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ	6
1.2 БАГШ НАРЫН ХЭРЭГЦЭЭНИЙ СУДАЛГАА	8
1.3 ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	11
1.4 ХӨТӨЛБӨРИЙН ҮЗЭЛ САНАА, ХАМРАХ ХҮРЭЭ.....	11
ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЗАРЧИМ	
2.1 ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	12
2.2 ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ	12
2.3 МУИС-ИЙН ПРОФЕССОР БАГШИЙН ЦОГЦ ЧАДАМЖИЙН ХҮРЭЭ	13
ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН, ҮНЭЛГЭЭ, ТӨСӨВ	
3.1 ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	14
3.2 ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	16
3.3 ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, САНХҮҮЖИЛТ	20
3.4 ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ	21
ДӨРӨВ. МУИС-ИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН	
4.1 ПРОФЕССОР, БАГШИЙН ЦОГЦ ЧАДАМЖИЙН ШАТАЛСАН ТОДОРХОЙЛОЛТ..	22
4.2 ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ ..	29
4.3 БАГШИЙН ХӨГЖЛИЙН ХУВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР.....	39
4.4 БХХ-ИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	40



1.1 МУИС-ИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ


МУИС-ийн Багшийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд дээд боловсролын олон улсын чиг хандлага, хүний нөөцийн бодлого, менежмент, их сургуулийн багшид тавигдаж буй шаардлага, тулгамдаж буй асуудал, багшийн хөгжлийг дэмжих төсөв санхүүгийн төлөв, байдалд гадаад, дотоод орчны дүн шинжилгээ хийв.

Дээд боловсролын байгууллагын мэргэжлийн хөгжлийн олон улсын сүлжээний үйл ажиллагааны зарчим, дэлхийн шилдэг их сургуулиудын Багшийн хөгжил, Багшлахуй, Суралцахуйн стратеги хөгжлийн бодлого, Судлаачийн хөгжлийн олон улсын байгууллагаас тодорхойлсон судлаачийн цогц чадамжийн хүрээг харьцуулан судалж, гадаад, дотоодын тэргүүлэх эрдэмтэд, судлаачдаас мэргэжлийн зөвлөгөө авч, үр дүнг өөрийн орны хөгжлийн түвшин, сургуулийн нөөц боломж, багшийн бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөтөлбөрт тусгав.

МУИС-ийн Стратегийн төлөвлөгөө (2016-2024) –ний алсын хараанд МУИС нь Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд багтаж, дэлхийн түвшний судалгааны их сургууль болно хэмээн тодорхойлоод “сургах ба сурах үйл явцыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэх”-д “багшлах шилдэг боловсон хүчнийг бүрдүүлж” ажиллах талаар стратегийн тэргүүлэх зорилтоо дэвшүүлсэн болно.

МУИС-д 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар нийт 593 багш ажиллаж байгаагийн 79 нь профессор, 200 нь дэд профессор, 155 нь ахлах багш, 115 нь багш, 34 багш дадлагажигч багшийн албан тушаалын зэрэглэлд тус тус ажиллаж байна. Нийт 338 багш докторын зэрэгтэй бөгөөд тэдний 292 нь профессор, дэд профессор, 35 нь ахлах багш, 11 нь багшийн орон тоонд ажиллаж байна (Зураг 1).

- ПРОФЕССОР
- ДЭД ПРОФЕССОР
- АХЛАХ БАГШ
- БАГШ
- ДАДЛАГАЖИГЧ БАГШ



Зураг 1. МУИС-ийн профессор, багш нарын бүтэц

Профессор, багш нарын судалгааны чадамж, үр дүнгээс харахад Web of Science-д бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн болон ишлэгдсэн тоо сүүлийн таван жилд өссөн байна. Тухайлбал 2014-2015 оны хичээлийн жилтэй харьцуулбал 2017-2018 оны хичээлийн жилд багш нарын хэвлүүлсэн өгүүллийн тоо 1.3 хувиар, ишлэгдсэн бүтээлийн тоо 5.57 хувиар тус тус өсч, оюуны өмчийн патент, мэдүүлгийн тоо сүүлийн 3 жилд өссөн дүнтэй байна.




Зураг 2. Web of Science -д бүртгэлтэй сэтгүүлд МУИС-ийн профессор, багш нарын хэвлүүлсэн өгүүлэл, ишлэлийн тоо




Зураг 3. МУИС-ийн профессор, багш нарын патентын мэдүүлэг, патентын гэрчилгээний тоо

МУИС-ийн бакалаврын сургалтын төлбөрийн орлогод багш, ажилтныг дэмжих зардлын эзлэх хувийн сүүлийн 5 жилийн дундаж нь 2.5 хувь байгаа нь Стратегийн төлөвлөгөөний зорилго хангаж байна. Гэвч багш, ажилтныг дэмжих зардлын зарцуулалтын төрөл, хэмжээ бүрэлдэхүүн сургууль бүрт харилцан адилгүй байгаад дүн шинжилгээ хийж, зарцуулалтын зорилго, чиглэлийг тодорхойлсон журам боловсруулан хэрэгжүүлэх шаардлага байна гэж үзэж байна (Зураг 3,4).



Зураг 4. МУИС-ийн бакалаврын сургалтын төлбөрийн нийт орлогод багш, ажилтныг дэмжих зардлын эзлэх хувь




Зураг 5. Багш, ажилтныг дэмжих зардлын зарцуулалт бүрэлдэхүүн сургуулиар

1.2 МУИС-ийн багш нарын академик хэрэгцээ, цогц чадамжийн судалгаа


МУИС-ийн профессор, багшийн хэрэгцээ, цогц чадамжийг тодорхойлох судалгааг сүүлийн 3 жилд авч үр дүнг багшийн хөгжлийн хөтөлбөрт тусгав. Тухайлбал 2016-2017 оны хичээлийн жилд багшийн хөгжлийн төвөөс МУИС-ийн багш нарын академик хөгжлийн эрэлт, хэрэгцээг тодорхойлох тандалт судалгааг нийт 376 (56%) багшаас авч үр дүнд үндэслэн үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэв. 2017-2018 оны хичээлийн жилд МУИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх бодит хэрэгцээ шаардлага, үндэслэлийг тодорхойлох зорилгоор хөтөлбөр боловсруулах эхний ажлын хэсгээс багшийн академик хөгжлийн хэрэгцээ, нийгмийн асуудлаар нийт 375 (56,6%) багшаас дэлгэрэнгүй судалгаа авч үр дүнг хөтөлбөрт тусгав. МУИС-ийн профессор, багшийн цогц чадамжийн хүрээг нарийвчлан тодорхойлох зорилгоор 2018-2019 оны хичээлийн жилд ажлын хэсгээс 32 чадамж бүхий нэмэлт судалгааг нийт 359 багшаас авч, үр дүнг фактор анализын аргаар боловсруулан хамгийн олон санал авсан 24 чадамжийг энэхүү хөтөлбөрийн цөм болгон оруулсан болно.

Дээрх хэрэгцээний судалгаануудад оролцсон багш нар сургалт, судалгааны арга зүйгээ сайжруулах, хувь хүний хөрвөх чадвараа дээшлүүлэх зэрэг асуудлаар 25-аас дээш хувийн санал өгсөн нь их сургуулийн багшийг тусгайлан хөтөлбөр боловсруулж, урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтөөр чадваржуулах шаардлага, эрэлт хэрэгцээ байгааг илтгэж байна. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 44-57 хувь нь мэргэжлийн болон гадаад хэлний мэдлэг, чадвараа дээшлүүлэх сургалтаас бусад сургалт, үйлчилгээг дотооддоо авахыг илүүд үзэж байгаа нь сургуулийн зүгээс багшийг хөгжүүлэх цогц хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх бодит хэрэгцээ, шаардлага өндөр байгааг харуулж байна (Зураг 6).




Зураг 6. 2018 онд авсан Багш нарын хэрэгцээний судалгааны дүнгээс

Профессор, багш нарын дунд сургалт, судалгааны арга зүй, хувь хүний хөгжлийн чадамжаа сайжруулах эрэлт хэрэгцээ өндөр байгаа хэдий ч, судалгаанд оролцогчдын олонх нь эрдэм шинжилгээ, судалгааны чадамж, үр дүнгээ цогцоор нэмэгдүүлэх үйл ажиллагааг ойрын зорилтоо гэж тодорхойлсон ба ялангуяа мэргэжлийн түвшинд хянагдааг олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэхийг өөрийгөө хөгжүүлэх хамгийн ойрын, чухал зорилт хэмээн судалгаанд оролцсон нийт 375 багшийн 244 нь буюу 65.1 хувь нь үзсэн байна (Зураг 7).



Зураг 7. 2018 онд авсан Багш нарын хэрэгцээний судалгааны дүнгээс

Багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр МУИС ямар үйл ажиллагаа явуулбал зохих талаар судалгаанд оролцсон багш нарын 58.9 хувь буюу 221 багш, Судлаач – багш, Судлаач, Багш – судлаач, Багшийн статусыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж, хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн үзсэн бол 58,4 хувь нь тэдний эрүүл мэнд, цалин, нийгмийн асуудлыг тусгасан бодлого боловсруулж хэрэгжүүлэх гэж хариулжээ. Харин судалгаанд оролцогчдын 34.5 хувь нь гадаад, дотоодын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл бичих арга зүйн сургалт зохион байгуулах, 29.9 хувь нь тэнхим, нэгж бүр багшийн хөгжлийн төлөвлөгөөтэй болох хэмээн үзсэн нь багшийг хөгжүүлэх асуудлаар нэгдсэн бодлого, төлөвлөлттэй байж, тэднийг чадавхжуулах сургалт, үйлчилгээ явуулах шаардлага байна гэж үзжээ. (Зураг 8.)



Зураг 7. 2018 онд авсан Багш нарын хэрэгцээний судалгааны дүнгээс

1.3 Хөтөлбөрийн нийтлэг үндэслэл, эрх зүйн зохицуулалт

2016 онд батлагдсан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030-д “тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгох” зорилтыг дэвшүүлж, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014- 2024)-ын 5.2, 5.3 -д дээд боловсролын хүний нөөцийн хөгжлийг дэмжих талаар “Багшийн мэргэжлийн үр чадвар, нэр хүнд, ёс зүй, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэн, хөдөлмөрийг бодитой үнэлэх тогтолцоог бүрдүүлэх...” “Боловсролын мэргэшсэн удирдах болон бусад ажилтныг хүний нөөцийн төлөвлөлт, бодлоготой уялдуулан сургаж бэлтгэх, дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ” хэмээн тодорхойлсон байна. Мөн 2018 онд батлагдсан Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 6.1-д “Багшийн мэдлэг, боловсрол, хандлага, ёс зүй, эрүүл мэнд, нийгмийн баталгаа, багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн үр чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөртэй байна” хэмээн заасан нь багшийг хөгжүүлэхэд төрөөс хууль эрх зүй, бодлогын түвшинд анхаарч байгааг илэрхийлэх баримт болж байна.

Энэхүү хөтөлбөрийн агуулга, үзэл санааг дээр дурьдсан хууль, эрх зүйн баримт бичгийн заалтуудад нийцүүлэхийн зэрэгцээ Боловсролын тухай хууль (2002), Дээд боловсролын тухай хууль (2002), Засгийн газрын “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010), Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2018), Монгол Улсын Их Сургуулийн Стратегийн төлөвлөгөө, 2016-2024 (2016) зэрэг бодлогын баримт бичгийн үзэл баримтлалд тулгуурлан хэрэгжүүлнэ.

1.4 Хөтөлбөрийн үзэл санаа, хамрах хүрээ

Энэхүү хөтөлбөрт МУИС-ийн багшийн мэргэжил, арга зүйн хөгжлийг цогцоор нь шийдвэрлэх, тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай орчин, нөхцөлийг сайжруулах, үнэлгээ, урамшууллын нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх зэргээр багшийн чадамж, ажлын үр дүнг дээшлүүлэн дэлхийн түвшний их сургууль болох алсын хараанд хүрэх үзэл санааг баримтална. Хөтөлбөрт МУИС-ийн багшийн албан тушаалын зэрэглэлд ажиллаж буй профессор, багш нар хамрагдах ба хэрэгжүүлэх үүргийг МУИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургууль болон захиргааны нэгжүүд хүлээнэ.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЗАРЧИМ

2.1 Хөтөлбөрийн зорилго, зорилт

МУИС-ийн Стратегийн төлөвлөгөөний багшлах шилдэг боловсон хүчнийг бүрдүүлэх тэргүүлэх зорилтын хүрээнд багшийн хөгжлийн тулгамдаж буй асуудлыг илрүүлж, шийдвэрлэх арга замыг сонгон, багшийн судалгаа, сургалт болон хувь хүний цогц чадамжийг тасралтгүй хөгжүүлэх боломж, нөхцөлийг хангахад хөтөлбөрийн зорилго чиглэн дараах зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

Зорилт 1

Багшийн тасралтгүй хөгжлийг умраллагын бүх шатанд нэгдсэн бодлогоор дэмжиж, багшийг хөгжүүлэх байгууллагын соёлыг төлөвшүүлэх.

Зорилт 3

Багшлахуйн цогц чадамж, чадавхийг нэмэгдүүлэх, сургах, суралцах үйл ажиллагааг шинэ шатанд гаргах.

Зорилт 2

Багш нарын судалгааны түвшинг олон улсын жишигт хүргэх шаардлагад нийцүүлэн тэдний судалгааны цогц чадамжийг хөгжүүлэх.

Зорилт 4

Багш нь академик байгууллагын соёл, хэм хэмжээг эрхэмлэн, түгээн дэлгэрүүлэх хүлээлт, шаардлагад нийцүүлэн хувь хүний цогц чадамжийг хөгжүүлэх.

2.2 Хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

- Хөтөлбөрийн бодлого, үйл ажиллагаа нь төрөөс боловсролын талаарх баримтлах бодлого, үндсэн чиглэл, МУИС-ийн хөгжлийн зорилтуудтай нийцсэн байх
- Багшийн хөгжлийн түвшин, эрэлт хэрэгцээ, сонирхол, боломж, итгэл үнэмшил, академик эрх чөлөө, бие даасан байдалд тулгуурлах
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нээлттэй, хүртээмжтэй, шударга байж, хүний эрх, жендерийн тэгш байдлыг хангах;
- Хөтөлбөрийг тасралтгүй, тогтвортой, нэгжүүдийн хамтын ажиллагааг уялдуулан хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангах;
- Олон улсын хөгжлийн чиг хандлага болон үндэсний онцлог, академик байгууллагын хэм хэмжээнд нийцсэн байх;

2.3 МУИС-ийн профессор багшийн цогц чадамжийн хүрээ

МУИС-ийн багшийн хөгжлийн төлөвлөгөө, хэрэгжүүлэх үйл ажиллагааг багшийн цогц чадамжид тулгуурлан төлөвлөж, зохион байгуулна. Цогц чадамж нь багшийн мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлно.

МУИС-ийн багшийн цогц чадамж нь багшийн албан тушаалын зэрэглэлд тавигдах суурь чадамжаар тодорхойлогдсон байна (Хавсралт 4.1). Албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлага, үнэлгээ, шинэ багшийн сонгон шалгаруулах үйл ажиллагаа нь багшийн хөгжил, цогц чадамжийн түвшинд үндэслэгдэн тодорхойлогдоно.

МУИС-ийн багшийн цогц чадамж, хөгжлийн загварыг боловсролын хөгжлийн орчин үеийн чиг хандлага, шаардлага, багш нарын хөгжлийн суурь түвшинд тулгуурлан боловсруулах ба хөтөлбөр хэрэгжүүлэх явцад үнэлгээ хийж өөрчлөлт оруулж болно.

МУИС-ийн багш нь судалгааны, сургалтын, хувь хүний гэсэн үндсэн 3 цогц чадамжийн хүрээнд тасралтгүй хөгжинө. (Зураг 8).

- **Судалгааны цогц чадамж:** Багш нь шинжлэх ухааны мэргэшсэн салбарын болон салбар дундын судалгааг олон улсын жишигт нийцүүлэн гүйцэтгэх мэргэжлийн өргөн бөгөөд гүнзгий мэдлэг, судалгааны арга зүй, ёс зүйг эзэмшсэн судлаач, эрдэмтэн байна.
- **Сургалтын цогц чадамж:** Багш нь сургах, суралцах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй, орчин үеийн сургалтын технологи, мэдээллийн хэрэгслийн дэвшилтэт хэлбэр, арга зүйд үндэслэн үр дүнтэй зохион байгуулах чадвартай байна.
- **Хувь хүний цогц чадамж:** Багш нь хувь хүний олон талт хөрвөх чадварыг өндөр түвшинд эзэмшсэн байхын зэрэгцээ академик байгууллагын соёл, үнэт зүйлийг эрхэмлэдэг, ёс зүйтэй, нийгмийг соён гэгээрүүлэгч бие хүн байна.



Зураг 8. МУИС-ийн профессор, багшийн цогц чадамжийн хүрээ



ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН, ҮНЭЛГЭЭ, ТӨСӨВ

3.1 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- МУИС-ийн Стратегийн төлөвлөгөө (2016-2024)-ний хэрэгжилтийн үе шаттай уялдуулан Багшийн хөгжлийн хөтөлбөрийг дараах 2 шаттай хэрэгжүүлнэ. Үүнд:

Нэгдүгээр үе шат: 2019-2021

Хоёрдугаар үе шат: 2022-2024

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг цогц чадамжид үндэслэн боловсруулах бөгөөд Багшийн хөгжил, цахим сургалтын төв болон бүрэлдэхүүн, салбар сургуулиуд хэрэгжилтийг ялгаатай зохион байгуулна (Хавсралт 4.3).
- Бүрэлдэхүүн, салбар сургуулийн захиргаа тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан удирдлагын ажлыг хэрэгжүүлэх ба багшийн хөгжлийн хувийн төлөвлөгөөний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажиллана.
- Багш өөрийн мэргэжлийн болон бусад чиглэлийн хөгжлийн ахиц дэвшлийг хувийн төлөвлөгөөнд үндэслэн хэрэгжүүлнэ (Хавсралт 4.4).
- Тухайн хичээлийн жилд багш нь хөгжлийн хувийн төлөвлөгөөнд тусгасан цогц чадамжийг дээшлүүлэх зорилгоор Багшийн хөгжлийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлээс сонгон судална. Багшийн хөгжлийг дэмжих сургалтын төлөвлөгөө нь цогц чадамжийн түвшин, сургалтын технологийн ялгаатай хэлбэр бүхий хичээлүүдээс бүрдэнэ (Хавсралт 4.5).
- Багшийн сургалт, судалгаа, хувь хүний цогц чадамжийг тасралтгүй хөгжүүлэхэд хөтөлбөрийн үндсэн 4 зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

Багшийн тасралтгүй хөгжлийг удирдлагын бүх шатанд нэгдсэн бодлогоор дэмжиж, багшийг хөгжүүлэх байгууллагын соёлыг төлөвшүүлэх зорилтот ажлын хүрээнд:

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад удирдлагын нэгдсэн бодлогоор дэмжиж ажиллах;
- Багшийн хөгжлийн хувийн төлөвлөгөөнд үндэслэн тэнхим, бүрэлдэхүүн, салбар сургууль багшийн хөгжлийн үйл ажиллагааны цогц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, албан тушаалын зэрэглэл бүрээр тодорхойсон цогц чадамжийн шалгуур үзүүлэлтээр үр дүнг үнэлэх;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад төсөв санхүүгээр тууштай дэмжих, бүрэлдэхүүн сургуулиудад хуваарилах багшийг дэмжих зардлын зарцуулалтын зорилго, чиглэлийг тодорхойлох;

Багш нарын судалгааны түвшинг олон улсын жишигт хүргэх шаардлагад нийцүүлэн тэдний судалгааны чадамжийг хөгжүүлэх зорилтот ажлын хүрээнд:

- Багшийн судалгааны арга зүйг сайжруулах, судлаачийн ёс зүйг төлөвшүүлэх, судалгааны төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, судалгаа удирдах зэрэг чиглэлээр сургалт зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- Өндөр түвшний мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, судалгааны грантад хандах, докторын дараах сургалтад хамрагдах, судалгааны төсөл боловсруулах зэрэгт шаардлагатай академик англи хэлний мэдлэг, чадварыг сайжруулахад чиглэсэн сургалт зохион байгуулах, хянан засварлах үйлчилгээ үзүүлэх;
- Салбар дундын судалгаа, олон улсын түвшний хамтарсан судалгаа хөгжлийн менежмент хийх, эрдэм шинжилгээний хурал, форум зохион байгуулах үр чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн хамтарсан төсөл, хөтөлбөр, санаачилга хэрэгжүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх;
- Олон улсад мэргэжлийн түвшинд хянагдааг сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, өгүүлэл хэвлүүлсэн багшийг урамшуулах;
- Багш судалгааны ном, сурах бичиг хэвлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, бүтээлээ сурталчлан таниулах тогтолцоог бүрдүүлэх;
- Зочин судлаач хөтөлбөр хэрэгжүүлэх

Багшлахуйн цогц чадамж, чадварыг нэмэгдүүлэх, сургах, суралцах үйл ажиллагааг шинэ шатанд гаргах зорилтот ажлын хүрээнд:

- Багшийн сургалтын арга зүйн мэдлэг, үр чадварыг шинэ шатанд гаргахад чиглэсэн сургалт зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, зөвлөн чиглүүлэх үйлчилгээ үзүүлэх;
- Сургах, суралцах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй, шинэлэг арга зүйгээр зохион байгуулах зорилгоор олон улсын дэвшилтэт, сайн туршлагыг нэвтрүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Дээд боловсролын сургах, суралцах үйл ажиллагаа, багшийн хөгжлийн хэрэгцээ, шаардлага, орчин үеийн чиг хандлага, инновацийн чиглэлээр судалгаа хийх, мэргэжлийн сэтгүүлд, сонин эрхлэн гаргах, сургуулийн болон үндэсний хэмжээний хурал, форум, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Сургах, суралцах үйл ажиллагааны инновацийг дэмжсэн тэтгэлэг, грант олгох
- Багш нарын харилцан суралцах бодит боломжийг бүрдүүлэх, ахмад, залуу багшийн Менторшип хөтөлбөр хэрэгжүүлэх



- Багш хичээл заах, хамтарсан, салбар дундын, олон улсын түвшний зэргийн болон зэргийн бус хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн англи хэлний мэдлэг, чадвар, арга зүйг сайжруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Технологийн дэвшилд суурилсан нээлттэй боловсролын үзэл санааг сургалтад нэвтрүүлэх, онлайн болон холимог сургалтын дизайн, сургалтын нээлттэй нөөц материал ашиглах, боловсруулах арга зүйн сургалт зохион байгуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;
- Багш солилцоо, зочин багшийн хөтөлбөр хэрэгжүүлэх;

Багш нь академик байгууллагын соёл, үнэт зүйлсийг эрхэмлэн, байх шаардлагад нийцүүлэн багшийн хувь хүний ёс зүйг төлөвшүүлэх, цогц чадамжийг хөгжүүлэх зорилготой ажлын хүрээнд:

- МУИС-ийн багшийн ёс зүйн дүрмийг академик байгууллагын соёлын онцлог, хэм хэмжээнд нийцүүлэн мөрдөх;
- Багшийн ажлын үнэлгээ, шинэ багшийн сонгон шалгаруулалт, суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны агуулга, шалгуур үзүүлэлтэд багшийн болон хувь хүний ёс зүй, цогц чадамжийн шаардлагыг тусгах;
- Багшийн хувь хүний ёс зүй, манлайлал болон хувь хүний хөрвөх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, семинар, вебинар, лекц, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Академик байгууллагын ажиллах орчин, уур амьсгал, ажлын бүтээмжийн суурь үндэс болох академик профессионализмыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, семинар, вебинар, лекц, хамт олны нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Академик байгууллагын хэм хэмжээ, соёлыг үл хүндэтгэх, хувь хүний ёс зүйг зөрчих зэрэг зохисгүй үйлдлийг зохицуулах хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх;

3.2 Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг цогц чадамж бүрийн шалгуураар тодорхойлох ба гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтээр үр дүнг үнэлнэ. Хөтөлбөрийн гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт (KPI) нь МУИС-ийн Стратегийн төлөвлөгөөний биелэлтийн үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

3.2.1 Бодлого, төлөвлөлтийн түвшинд:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай удирдлага зохион байгуулалт, хөрөнгө санхүү, орчин нөхцөлөөр хангах асуудлыг шат шатанд дэмжсэн удирдлагын нэгдсэн тогтолцоо бий болно.
- Багш бүрийн сургалт, судалгаа, хувь хүний хөгжлийн хэрэгцээнд үндэслэсэн хөгжлийн хувийн төлөвлөгөө нь тэнхим, бүрэлдэхүүн сургууль болон МУИС-ийн тухайн хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний үндэс суурь бүхий шаталсан төлөвлөлт бүрдэнэ.
- Хөтөлбөрийн үйл ажиллагааны болон сургалтын төлөвлөгөөг чанартай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, сургагч багш нарыг бодлогоор бэлтгэн, тэдэнд тавигдах сургалтын агуулга, арга зүй, ур чадварын нэгдсэн стандарт бий болно.
- Хөтөлбөрт идэвхтэй хамрагдан бодит үр дүнд хүрсэн багшийг урамшуулан дэмжих, түүнчлэн академик хамт олонд хүлээн зөвшөөрөгд сөн шилдэг багшийг хадгалах, карьерын өсөлтийг нь дэмждэг байгууллагын соёл бий болно.

3.2.2. Судалгааны түвшинд:

- Багш нар судалгаа хийх, удирдах арга зүйн хувьд чадавхиж, судлаачийн ёс зүй, академик эрх чөлөөг дээдэлсэн байгууллагын соёл төлөвшинө.
- Олон улсад хянан магадлагддаг Journal Citation Reports-ын индекстэй мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн нэг багшид ногдох бүтээлийн тоо, судалгааны грант, төсөл хөтөлбөрт хамрагдах, докторын дараах болон ахисан түвшний судалгаа хийх, зочин судлаачаар ажиллах зэргээр эрдэм шинжилгээний олон төрөлт ажил оролцсон багшийн тоо тус тус өснө.
- Олон улсын, үндэсний, салбар дундын хамтарсан судалгаа удирдах, хөгжүүлэх багшийн мэргэжил, арга зүйн чадамж дээшилж, бүс нутгийн цаашилбал олон улсын түвшинд шинжлэх ухааны хөгжил, ололт амжилтад хувь нэмэр оруулдаг багшийн тоо өснө.
- Багш судалгааны бүтээл хэвлүүлэх, өндөр үр бүтээмжтэй багшийг урамшуулан санхүүгийн дэмжлэг үзүүлдэг тогтолцоо боловсронгуй болно.
- Докторант багш нар судалгааны арга зүйг сайжруулах, судалгаа хийхэд нь зөвлөн туслах, чиглүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, эрдмийн зэрэг хамгаалахад нь удирдлага, санхүүгээр дэмжих механизм бий болж улмаар эрдмийн зэрэг, цолтой багшийн тоо өснө.

3.2.3 Сургалт, арга зүйн түвшинд:

- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг орчин үеийн шаардлагад нийцүүлэн боловсруулах, судалгаанд суурилсан сургах, суралцах үйл ажиллагааг хөгжүүлэх, сургалтад технологийн дэвшилтэт арга, хэлбэрийг үр дүнтэй хэрэглэх, онлайн болон холимог сургалтын арга зүйг нэвтрүүлэх зэргээр сургах, суралцах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах чадвартай багшийн тоо нэмэгдэж суралцагчдын сэтгэл ханамжийн индекс өснө.
- Сургах, суралцах үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, хичээлийн хөтөлбөрийг шинэ, шинэлэг арга зүйгээр баяжуулах, суралцагчдыг сэдэлжүүлэх, хувь хүний хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн идэвхтэй сургалтын аргыг сургалтад хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг бодитой үнэлэх дэвшилтэт арга, хэлбэрийг хэрэглэх, турших зэргээр сургах, суралцах үйл ажиллагааны инновацийг хөгжүүлсэн багшийг урамшуулан дэмждэг механизм бий болно.
- Ахмад, залуу багшийн хамтын ажиллагааг дэмжих Менторшип хөтөлбөр хэрэгжсэнээр багшлахуйн уламжлалт философи, сургалтын шинэ технологи, арга зүйгээс харилцан суралцах, сургалтын олон талт үйл ажиллагааг хамтран зохион байгуулах боломж бүрдэн, улмаар зөвлөх профессор багш өөрийн мэргэшсэн салбарт залуу үеийг дагалдуулан бэлтгэдэг, шинэ, залуу багшийн мэдлэг, чадварыг бодитой үнэлдэг байгууллагын соёл бий болно.
- Дээд боловсролын салбарын сургалтын дэвшилтэт чиг хандлага, сайн туршлагаас тасралтгүй суралцан боловсролын хөгжил, сургах, суралцах үйл ажиллагааны инновацийн чиглэлээр сонирхон судалдаг, бүтээл хэвлүүлдэг багшийн тоо өснө.

3.2.4 Академик байгууллагын соёл, хувь хүний түвшинд:

- Академик хамт олны өмнө хүлээх багшийн эрх, үүргээ биелүүлдэг, багшийн болон хувь хүний ёс зүйн дүрэм, журмыг чанд мөрддөг хариуцлага дээшилж, үр дүнг бодитой тооцдог тогтолцоо бий болно.
- МУИС-ийн профессор, багш нь байгууллагын хэм хэмжээ, үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлж, хамт олон, нийгэмд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар, эерэг хандлагаар үлгэрлэн, нийгмийг соён гэгээрүүлэх үүрэг, хүлээлт бүхий академик соёл төлөвшинө.
- Хөтөлбөр хэрэгжсэнээр профессор, багшийн ажлын үнэлгээ, албан тушаалын зэрэглэл тогтоох, удирдах ажилтныг судлан шалгаруулах, шинэ багшийг сонгон шалгаруулах, багшийн талаарх суралцагчдын үнэлгээ зэрэг үйл ажиллагааны шалгуур, шаардлагад багшийн болон хувь хүний ёс зүй, ур чадвар, хандлагыг харгалзан үнэлдэг тогтолцоо бий болно.





3.3 Хөтөлбөрийн удирдлага, санхүүжилт

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй уялдуулан бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө багшийн хөгжлийн чиглэлээр зорилтот ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлнэ.
- Багшийн хөгжил, цахим сургалтын төв нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд холбогдох дэд захирлаар жил бүр ажлын төлөвлөгөө батлуулан мөрдөж ажиллана.
- Багшийн хөгжил, цахим сургалтын төв нь захиргааны нэгж, бүрэлдэхүүн, салбар сургууль, тэнхимтэй хамтран багшийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- Багш өөрийн хөгжлийн хувийн төлөвлөгөөг боловсруулахад дараагийн хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусган тухайн хичээлийн төгсгөл буюу 5 дугаар сард багтаан тэнхимийн эрхлэгчээр хянуулж, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлаар батлуулна.
- Багшийг хөгжүүлэх, мэргэжил дээшлүүлэх нэгжийн ажлын төлөвлөгөөг МУИС-ийн Стратегийн төлөвлөгөө, Багшийн хөгжлийн хөтөлбөр, багшийн хөгжлийн хувийн төлөвлөгөөнд үндэслэн тэнхим, бүрэлдэхүүн, салбар сургууль тус бүр боловсруулан баталгаажуулж, хувийг 6 дугаар сарын 15 ны дотор Багшийн хөгжил, цахим сургалтын төвд ирүүлнэ.
- Батлагдсан төлөвлөгөөний дагуу багшийг ажлын байранд нь хөгжүүлэх үйл ажиллагааг бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч нар зохион байгуулж хяналт тавина.
- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны нийт санхүүжилтийг хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй хамт батална (Хавсралт 4.3).
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

*МУИС-ийн төвлөрсөн болон бүрэлдэхүүн, салбар сургуулиудын төсөв
Улсын төвлөрсөн төсөв
Зорилтот төсөл, хөтөлбөр
Эрдэм шинжилгээ, судалгааны санхүүжилт
Хандив, тусламж
Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр*

- Бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал нэгжийн төлөвлөгөөнд үндэслэн жил бүрийн төсөвт багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг төлөвлөнө.



- Хөтөлбөрийн санхүүжилтийг холбогдох нэгжүүдийн саналыг үндэслэн Санхүү төлөвлөлтийн газар төлөвлөж, МУИС-ийн Удирдах зөвлөл батална.
- Багш нь багш, ажилтныг дэмжих үйл ажиллагааны зардлыг хөгжлийн хувийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зориулж зарцуулна

3.4 Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ

- Хөтөлбөрийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтийг зохицуулах үүргийг Сургалт, о ю у т а н хариуцсан дэд захирал болон Багшийн хөгжил, цахим сургалтын төв, хянах, үнэлэх үүргийг Хяналт, мониторингийн алба хэрэгжүүлнэ.
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд Хяналт, мониторингийн алба үр нөлөөллийн шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тухайн жилийн 8 дугаар сард багтаан Захиргааны зөвлөлд танилцуулна.
- Хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүн, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, ш а л г у у р үзүүлэлтэд нэмэлт өөрчлөлт оруулна.
- Багшийн хөгжил, цахим сургалтын төв багшийн академик хөгжлийн хэрэгцээ шаардлага, сэтгэл ханамжийн судалгааг ил бүр хийж үр дүнг хөтөлбөрийг сайжруулахад тусгана.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын хэрэгжилт, багшийн хөгжлийг дэмжих сургалтын үйл явцаар хэмжиж, хяналт т а в и х боломжтой бөгөөд үр дүнг багшийн албан тушаалын зэрэглэл, багшийн үнэлгээний шалгуур үзүүлэлтээр тооцож болно.

ДӨРӨВ. МУИС-ИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХАВСРАЛТ

4.1 Профессор, багшийн цогц чадамжийн шаталсан тодорхойлолт

1. СУДАЛГАНЫ ЦОГЦ ЧАДМЖ

Албан тушаал

Мэдээг, чөлөөт хандлага	Дамдгажигч багш	Багш	Ахлах багш	Дэд профессор	Профессор
1.1 Шинжлэх ухааны мэдээ	Шинжлэх ухааны мэргэшсэн салбарын мэдлэгээ өргөжүүлэх	Мэргэшсэн салбарын мэдлэгээ ашиглан мэргэжлийн түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц бүтээл туурвих	Мэргэшсэн салбар болон дундын шинжлэх ухааны сүүлийн үеийн ололтыг үнэлэх, нэгтгэн дүгнэх	Мэргэшсэн салбар болон салбар дундын судалгааны шинжлэх ухааны ололт, бүтээл туурвих	Мэргэшсэн салбар болон салбар дундын судалгааны шинжлэх ухааны ололт, бүтээл туурвих
1.2 Судалгааны ёс зүй	Судалгааны онол, арга байж судалгаанд үр бүтээлтэй оролцох	Судалгааны онол, арга зүйн мэдлэг чадвартай байж судалгаанд үр бүтээлтэй оролцох	Шинжлэх ухааны салбарын судалгаа ба хөгжлийн аливаа асуудлын шийдийг олох	Шинжлэх ухааны ололт амжилтыг практикт нэвтрүүлэх зэргээр үндэсний хөгжилд хувь нэмэр оруулах	Шинжлэх ухааны ололт амжилт гаргах, тэдгээрийг практикт нэвтрүүлэх зэргээр хүн төрөлхтний хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах
1.3 Хэвлэл мэдээлэл	Судалгааны ажлын үр дүнгээ мэргэжлийн түвшинд хянагдаг дотоодын сэтгүүл хамтран хэвлүүлэх	Судалгааны ажлын үр дүнгээ мэргэжлийн түвшинд хянагдаг дотоодын сэтгүүл зохиогчоор хэвлүүлэх	Судалгааны чиглэлийн үндэсний нийгэмлэг, холбоо, зөвлөлийн гишүүн байж мэргэжлийн үйл ажиллагаанд нь оролцох	Судалгааны чиглэлийн үндэсний нийгэмлэг, холбоо, зөвлөлийн үйл мэргэжлийн тодорхой хувь нэмэр оруулах	Судалгааны чиглэлийн үндэсний болон олон улсын нийгэмлэг, холбоог тэргүүлэх, умирдах зөвлөлд ажиллах, үйл ажиллагаанд нь манлайлан оролцох
1.4 Мэдээлэл	БҮРЭЛДЭХҮҮН сургууль/тэнхим/ нэгжийн түвшинд мэдлэгээ судалгааны семинарт илтгэл хэлэлцүүлэх	МУИС-ийн эрдэм шинжилгээний хурал аман болон ханан илтгэл хэлэлцүүлэх	Үндэсний эрдэм шинжилгээний хурал болон ханан илтгэл хэлэлцүүлэх	Олон улсын эрдэм шинжилгээний хурал аман болон ханан илтгэл хэлэлцүүлэх	Олон улсын эрдэм шинжилгээний хурал уригдсан илтгэл хэлэлцүүлэх, үзэсгэлэн гаргах
1.5 Судалгаа үйлдэл	Судалгааны ажил сонирхолтой суралцагчдад судалгааны арга зүйг танилцуулах, ойлгуулах	Бакалаврын судалгааны ажил удирдах, чиглүүлэх, шүүмжлэх	Бакалавр, магистрантын судалгааны ажил удирдах, шүүмжлэх	Магистрант, докторантын судалгааны ажил удирдах, шүүмжлэх	Магистрант, докторант, докторын дараах судалгааны ажил удирдах, шүүмжлэх
1.6 Хэлний мэдлэг, чөлөөт хандлага	Хамтарсан эрдэм шинжилгээний хэвлүүлэх/ эрхэлчүүдэд эх хэлний эрдэм шинжилгээний найруулгын хэм хэмжээ, шаардлагад нийцүүлэх	Бие даан эрдэм шинжилгээний хэвлүүлэх/ эрхэлчүүдэд эх хэлний эрдэм шинжилгээний найруулгын хэм хэмжээ, шаардлагад нийцүүлэх	Үндэсний хэмжээнд хамтарсан эрдэм шинжилгээний хэвлүүлэх/ хэлэлцүүлэхэд эх эрдэм шинжилгээний найруулга болон академик ангил хэлний стандарт, шаардлагад нийцүүлэх	Үндэсний болон олон улсын түвшинд бие даан эрдэм шинжилгээний өгүүлэл, хэлэлцүүлэхэд академик ангил хэлний стандарт шаардлагад нийцүүлэх	Үндэсний болон олон улсын түвшинд бие даан эрдэм шинжилгээний өгүүлэл, хэлэлцүүлэхэд академик ангил хэлний стандарт шаардлагад нийцүүлэх
1.7 Төсөл, туслахын менежмент	Дотоодын шинжилгээ, төсөл судалгааны туслахаар ажиллах	Дотоодын шинжилгээ, төсөл судалгааны туслахаар ажиллах	Өөрийн болон хамтарсан судалгааны төслийн саналыг төсөл голлох судлаачаар оролцох	Мэргэжлийн өгүүллийг хянан магадлах түвшний академик эх хэлний чөлөөтэй байх	Академик түвшний англи хэл дээр хэвлэгдээг мэргэжлийн сэтгүүлийн өгүүллийг хянан магадлах чөлөөтэй байх





1.3 Салбар дундын судалгаа	Шинжлэх ухааны салбарын хөгжлийн чиг хандлага, салбар дундын судалгааны талаар ойлголтой байх	Үндэсний түвшний мэргэжлийн нийгэмлэг, байгууллагуудад төслийн судалгааны үр дүнгээ	Олон нийтийн хэлэлцүүлэг, маргаан мэтгэлцээнд оролцох, хувь хүн байгууллагад өөрийн судалгааны оюуны болон нийгэм, соёл, эдийн засгийн үр нөлөөг дамжуулах	Оюуны өмчийн патент, лиценз гарааны байгуулах хөтөлбөрт оролцох	Практик ач холбогдол бүхий патент өмчийг оюуны үр дүнгээ, гарааны нутагшуулах, бий болгох зэргээр судалгааны инновацийг хөгжүүлэхэд оролцох	Онцгой үр нөлөөтэй патент гаргах, гарааны компанийг амжилттай авч явах, зөвлөх зэргээр судалгааны инновацийг бий болгоход хувь нэмэр оруулах
1.4 Салбар дундын судалгаа	Шинжлэх ухааны салбарын хөгжлийн чиг хандлага, салбар дундын судалгааны талаар ойлголтой байх	Үндэсний түвшний мэргэжлийн нийгэмлэг, байгууллагуудад төслийн судалгааны үр дүнгээ	Олон нийтийн хэлэлцүүлэг, маргаан мэтгэлцээнд оролцох, хувь хүн байгууллагад өөрийн судалгааны оюуны болон нийгэм, соёл, эдийн засгийн үр нөлөөг дамжуулах	Оюуны өмчийн патент, лиценз гарааны байгуулах хөтөлбөрт оролцох	Практик ач холбогдол бүхий патент өмчийг оюуны үр дүнгээ, гарааны нутагшуулах, бий болгох зэргээр судалгааны инновацийг хөгжүүлэхэд оролцох	Онцгой үр нөлөөтэй патент гаргах, гарааны компанийг амжилттай авч явах, зөвлөх зэргээр судалгааны инновацийг бий болгоход хувь нэмэр оруулах
1.5 Судалгааны санхүүжилт	Өөрийн судалгааны ажил, төслийг санхүүжүүлэх тэтгэлэг, грант, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн мэдээллийн эх үүсвэрийн тухай ойлголтой байх	Өөрийн судалгааны ажил, төслийг санхүүжүүлэх тэтгэлэг, грант, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг олох арга замыг мэдлэг байх	Салбар дундын судалгааны багийн үндсэн судлаачаар ажиллах	Салбар дундын судалгааны багийн үндсэн судлаачаар ажиллах	Үндэсний болон сургуулийн багтай хамтарч салбар дундын судалгааны ажил төсөл санаачлах, хэрэгжүүлэх	Гадаадын их сургууль/байгууллагатай хамтарсан салбар дундын судалгаанд оролох, удирдах, өргөжүүлэх
			Судалгааны төсөл, хөтөлбөрт оролцох замаар төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн менежментийн арга зүй эзэмшсэн байх	МУИС-д судалгааны хөрөнгө оруулалтыг мөнгөн болон материаллаг хэлбэрээр оруулах байх	Нэр хүндтэй, өрсөлдөх чадвартай, өргөн хүрээний үндэсний төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, төсөв хөрөнгө босгох	Нэр хүндтэй, өрсөлдөх чадвартай, өргөн хүрээний үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, төсөв хөрөнгө босгох

2. СУРГАЛТЫН ЦОГЦ ЧАДМЖ

Албан тушаал

	Азлаагүйч багш	Багш	Ахлах багш	Дээд профессор	Профессор
2.1 Боловсрол судалгааны мэдлэг	Боловсролын хөгжлийн чиг хандлага, үзэл баримтлалын талаар ойлголтой байх түүнийг сургалтад ашиглах	Боловсролын хөгжлийн чиг хандлага, үзэл баримтлалын талаар ойлголтой байх түүнийг сургалтад ашиглах	Боловсролын хөгжлийн чиг хандлага, үзэл баримтлалын талаар мэдээллийн хүрээгээ өргөжүүлэх, сургалтын агуулгад тусгах	Сургалтын хөтөлбөрийг боловсролын хөгжлийн үзэл баримтлалтай уялуулан сайжруулах боловсруулах	Сургалтын хөтөлбөрийг боловсролын хөгжлийн үзэл баримтлалтай уялуулан шинээр болон шинэчлэн боловсруулах
2.2 Багшлал	Сургалтын хөтөлбөр дэх хичээл хоорондын залгамж холбоог ойлгон сургалтыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах	Сургалтын хөтөлбөр дэх хичээл хоорондын залгамж холбоог ойлгон сургалтыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах	Хичээлийн агуулгыг өмнөх болон залгамж хичээлтэй уялуулан шинжлэх ухааны үндэстэй боловсруулах	Хичээлийн агуулгыг өмнөх тухайн шинжлэх ухааны үеийн ололт амжилтад тулгуурлан хөгжүүлэх	Хичээлийн агуулгыг салбар дундын хөтөлбөрийн агуулгад нийцүүлэн интегралчлах
2.3 Сургалтын зуралдлуур	Багшлахуйн үр чадвараа орчин үеийн судалгаанд үндэслэн хөгжүүлэх	Суралдагчийн сэтгэл ханамжийн судалгаа, хамтран ажиллагчийн саналыг тусган багшлахуйн үр чадвараа хөгжүүлэх	Суралдагчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг ашиглан багшлахуйн үр чадварыг үнэлэх, билэ даан хөгжүүлэх	Сургах, суралцах үйл ажиллагааны шинэ арга зүйг хөгжүүлэх, түгээх, бусадтай хуваалцах	Сургах, суралцах үйл ажиллагааны инновацийг бий болгох, докторант, магистрант, залуу багш нарыг дагуулан сургах
2.4 Хөтөлбөр боловсруулах	Хичээлийн хөтөлбөрийн дагуу сургалтыг чанартай зохион байгуулах	Хичээлийн хөтөлбөрийн дагуу сургалтыг чанартай зохион байгуулах	Хичээлийн зорилго, агуулгад нийцүүлэн сургалтын хэрэгжлэхүүнийг сонгох, бүтээлчээр хэрэглэх	Судалгааны үр дүнг сургалтын хэрэгжлэхүүн болгон хэрэглэх	Судалгааны үр дүнг сургалтын шинэ, шинэлэг хэрэгжлэхүүн бий болгох, түгээх
2.5 Сургалтын үнэлгээ	Хичээлийн хөтөлбөрийн бүтэц, зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар суурь ойлголтой байх	Хичээлийн хөтөлбөрийн бүтэц, зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар суурь ойлголтой байх	Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, үр дүнд нийцүүлэн хичээлийн хөтөлбөрийг боловсронгуй болгох	Судалгааны үр дүнг, шинэ мэдээллийг бүх түвшний хичээлийн хөтөлбөрийг боловсруулахад ашиглах	Ахисан түвшний хичээлийн хөтөлбөрийн залгамж, онцлогийг тодорхойлох, шинэ хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх
	Суралдагчийн суурь мэдлэг, чадвар, хандлагыг зөв оношлох	Суралдагчийн чанарт оюутны өмнөх судалгааны үр дүнд нийцүүлэн үзүүлэх үр нөлөөг тогтоох	Суралдагчийн өмнөх судалгааны үр дүнд нийцүүлэн хичээлийг зохион байгуулах	Суралдагчийн өмнөх судалгааны үр дүнд тохируулан хичээлийг зохион байгуулахад бусад зөвлөх туслах	Суралдагчийн өмнөх судалгааны үр дүнд тохируулан хичээлийг зохион байгуулахад бусад зөвлөх туслах
	Сургалтын хөтөлбөрийн бүтэц, зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар суурь ойлголтой байх	Сургалтын хөтөлбөрийн бүтэц, зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар суурь ойлголтой байх	Сургалтын хөтөлбөрийн бүтэц, зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар суурь ойлголтой байх	Сургалтын хөтөлбөрийн бүтэц, зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар суурь ойлголтой байх	Сургалтын хөтөлбөрийн бүтэц, зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар суурь ойлголтой байх
	Холбогдох дүрэм, журмын дагуу суралдагчид үнэлгээний зарчим болон үр дүнг танилцуулах	Холбогдох дүрэм, журмын дагуу суралдагчид үнэлгээний зарчим болон үр дүнг танилцуулах	Холбогдох дүрэм, журмын дагуу суралдагчийн үнэлгээний зарчим, арга хэмбэр, үр дүнг заллан шинжлэх	Суралдагчийн үнэлгээнд заллан шинжилгээ хийж үнэлгээний зарчмыг боловсронгуй болгох	Үнэлгээний үр дүнг сургалтын хөтөлбөрийг сайжруулахад оновчтой хэрэглэн сургах, суралцах үйл ажиллагааг хөгжүүлэх



Суралцагчдын үнэлгээнд задлан шинжилгээ хийж амжилтын түвшинг тодорхойлох арга зүйтэй байх	Суралцагчийн үнэлгээнд задлан шинжилгээ хийж, үр дүнг сургалтын чанарыг сайжруулахад ашиглах	Хичээлийн суралцахуйн үр дүнг бүрэн үнэлэх шинэ эрхлүүлэх, бий болгох, түүгээ	Хичээлийн суралцахуйн үр дүнг бүрэн үнэлэх шинэ эрхлүүлэх, бий болгох, түүгээ
Хичээлийн явцын болон эсийн үнэлгээний тохирох арга хэлбэрийг зохистой хэрэглэх	Хичээлийн суралцахуйн үр дүнд задлан шинжилгээ хийж, суралцахуйг сайжруулахад ашиглах	Сургалтын хөтөлбөрийн үнэлгээг оновчтой шинжилгээ хийх, хэрэгжүүлэхэд манлайлах	Сургалтын хөтөлбөрийн үнэлгээг загварлах, оновчтой эсэхэд дүн шинжилгээ хийх, хэрэгжүүлэхэд манлайлах
Ерөнхий сүүрийн хөтөлбөрийн суралцагчдад олон талт асуулаар зөвлөгөө өгөх, чиглүүлэх	Бакалавр, магистрантын суралцахуйн үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх, судалгааны ажлын шийдлийг олж харах, сорилтыг даван туулахад туслах	Шинэ, залуу багш нарыг сургалт, судалгааны ажил зөвлөн туслах; Суралцагч, академик хамт олны бие даасан байдлыг дэмжих	Чадаврал багш, судлаачийг бэлтгэх, төлөвшүүлэхэд зөвлөн туслах; Суралцагч, академик хамт олны бие даасан байдлыг дэмжих
Суралцагчдын сүүр мэдлэг, оюуны чадамж, хүсэл сонирхол, сэдэл тэмүүлэл, сурах арга барил, хөгжлийн шат харилцан амилгүй хөгжлийн шат харилцан амилгүй үр дүнг сургалтад тооцож ажиллах	Суралцагчдын сүүр мэдлэг, оюуны чадамж, хүсэл сонирхол, сэдэл тэмүүлэл, сурах арга барил, хөгжлийн шат харилцан амилгүй байгааг дүн шинжилгээ хийж үр дүнг сургалтад тооцож ажиллах	Суралцагчдын сурах арга барил, хөгжлийн шат харилцан амилгүй байдал хүчин зүйлийг заллан шинжлэх, судалгааны үр дүнг сургах, суралцах үйл ажиллагааг сайжруулахад ашиглах	Суралцагчдын хэрэглээ шаардлагад нөлөөлөх цогц хүчин зүйлийг заллан шинжлэх, судалгааны үр дүнг сургах, суралцах үйл ажиллагааг сайжруулахад ашиглах
Сургалтын явцад оюутныг татан оролцуулах арга хэлбэрийг мэддэг байж, суралцагч бүрт хандан хүндэтгэлтэй хандан итгэлтэй бий болгох	Суралцагчдын хамтын үйл ажиллагаанд хувь нэмэр оруулж буй суралцагчдад таархах, урам өгөх	Танхимын болон онлайн сургалтад интерактив, идэвхтэй сургалтын орчин бүрдүүлэх, суралцахуйг сэдэлжүүлэх олон талт арга хэлбэрийг турших	Сургах, суралцах таатай орчин, уур амьсгалыг дэмжих шинэ, шинэлэг арга хэлбэрийг санаачлан хэрэгжүүлэх, бусдад түгээн дэлгэрүүлэх

3. ХУВЬ ХҮНИЙ ЦОГЛ ЧАДАМЖ

Албан тушаал

Мэдлэг, чадвар, хандлага	Аллага	Ажил багш	Дэм профессор	Профессор
